



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/403

Арвайхээр

Эрх шилжүүлэх тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн А/254 дүгээр захирамжийн хавсралтын 4-т тусгагдсан эталон, тоног төхөөрөмжийн зардал 11,900,000 (арван нэгэн сая есөн зуун мянга) төгрөгийг зарцуулах эрхийг Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга Г.Мөнхтөр, хавсралтын 24-т тусгагдсан Нарийнтээл сумын Засаг даргын Тамгын газрын барилгын засварын зардалд 40,000,000 (дөчин сая) төгрөгийг зарцуулах эрхийг Нарийнтээл сумын Засаг дарга Б.Сугарт нарт тус тус шилжүүлсүгэй.

2.Худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг Стандарт, хэмжилзүйн хэлтсийн дарга Г.Мөнхтөр, Нарийнтээл сумын Засаг дарга Б.Сугар нарт даалгасугай.

3.Санхүүжилтийг хуваарийн дагуу олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



О.БАТЖАРГАЛ

011100901